



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ

Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ

2019 оны 12-р сар




МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 19,314 3.3% (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)
ТОП-20



МХБ-А индекс, 9,476 8.3%, МХБ-В индекс 7,845 1.1% (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



Олон улсын индексүүд

Индекс	2019.11.30	2019.12.31	Өөрчлөлт, %
DJIA (US)	28,051	28,462	1.4%
S&P 500 (US)	3,140	3,230	2.8%
Nikkei 225 (JP)	23,293	23,656	1.5%
Hang Seng (HK)	26,346	28,319	7.5%
DAX 30 (DE)	13,236	13,249	0.1%
SMI (CH)	10,493	10,616	1.2%

Валютын ханш

Валют	2019.11.30	2019.12.31	Өөрчлөлт, %
USD	2,715.22	2,734.33	0.7%
EUR	2,989.86	3,063.54	2.4%
JPY	24.80	25.17	1.4%
RUB	42.36	44.06	4.0%
CNY	386.41	392.39	1.5%
KRW	2.30	2.37	3.0%

Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	4.7	-76%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,690.3	+6.3%
Бүртгэлтэй компани	198	198
Арилжаалагдсан хувьцаа	75	+0
Арилжаалагдсан өдөр	22	+3

Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2019.11.30	2019.12.31	Өөрчлөлт, %
DAR	2,111.00	4,243.00	+100%
NEH	10,200.00	13,980.00	+37%
MIE	6800.00	91.00	+34%
HSX	390.00	523.88	+34%
TAH	10,000.00	13,100.00	+31%

Хамгийн их бууралттай

Хувьцаа	2019.11.30	2019.12.31	Өөрчлөлт, %
NKT	55.00	37.00	-32%
IND	1,900.00	10,200	-26%
SOH	920.00	750	-25%
DHU	1,850.00	1,550.00	-22%
ADL	1,135.00	964.75	-18%

Зах зээлийн мэдээлэл

Хорго хайрхан ХК өөрчлөн байгуулагдав

МХБ-ийн III ангилалд бүртгэлтэй Хорго хайрхан ХК-ийг Монгол даатгал ХХК-д нэгтгэх замаар өөрчлөн байгуулж, оноосон нэрийг Монгол даатгал ХК болгон өөрчилж, бирж болон СЗХ-д бүртгүүлсэн байна.

Мандал даатгал ХК-ийн хувьцаа хуваагдлаа

MSE:MNDL 1:100 хуваагдлын гүйцэтгэл дуусч, 12-р сарын 16-ны өдөр арилжааг нь сэргээсэн. Энэ нь хэрэв та 10 ширхэг хувьцаатай байсан бол 1,000 ширхэг болж, хувьцааны хаалтын ханш 5,200 төгрөг байсан бол 52 төгрөг болно гэсэн үг юм. Хувьцааг ийнхүү хуваах нь нэгж хувьцааны үнийг бууруулж, арилжааны идэвхийг өдөөх ач холбогдолтой байдаг.

Говь ХК 2018 оны ногдол ашгаа тарааж дуусав

Говь ХК 2018 оны цэвэр ашгаасаа ногдол ашиг болгон, нэгж хувьцаанд 6.12 төгрөг хуваарилсныг компанийн байран дээрээс, мөн хүсэлтээр бэлэн бусаар тарааж байсан бол ногдол ашгаа аваагүй үлдсэн хувьцаа эзэмшигдийн ногдол ашгийг 12-р сарын 31-ний өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ) дэх дансдуудад нь байршуулжээ.

Код	Компанийн нэр	Бүртгэх өдөр	Нэгж хувьцаанд олгосон ногдол ашиг/төг/	ХЗ-ийн тоо	Хувьцааны тоо	Дансанд байршуулсан ногдол ашиг/төг/
354	"Говь"ХК (GOV)	2019-03-28	6.12	16,473	76,352,838	466,852,056.56

ҮЦТХТ-д нээгдсэн дансны мэдээлэл

ҮЦТХТ-д 12-р сард нийт 11,240 данс нээгдсэнээс 10,061 данс шинээр, 1,179 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 10,056 дотоодын иргэн, 1 гадаадын иргэн, 4 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

Хөвсгөл геологи ХК 2018 оны ногдол ашгаа тараав

Хөвсгөл геологи ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд ногдох 0.90 төгрөгийг 12-р сарын 30-ны өдөр ҮЦТХТ дэх хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулав.

Код	Компанийн нэр	Бүртгэх өдөр	Нэгж хувьцаанд олгосон ногдол ашиг/төг/	ХЗ-ийн тоо	Хувьцааны тоо	Дансанд байршуулсан ногдол ашиг/төг/
195	"Хөвсгөл геологи"ХК (HUV)	2019-04-05	0.90	817	3,231,800	2,908,620.00

Евразиа капитал холдинг ҮЦК ХК-ийн хурал хойшлов

Еврази капитал холдинг ҮЦК ХК-ийн (MSE:SUN) Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц бүрдээгүй учир хойшлуулан, 2020 оны 1-р сарын 15-ны өдрийн 11:00 цагт дахин хуралдуулахаар болжээ.

Бүртгэх өдөр: 2019.12.02-ны өдөр

Хуралдах газар: СБ дүүрэг 1-р хороо, Олимпын гудамж, Реженс Ресиденс байр, 3 давхарт 314 тоот

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
2. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
3. Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх;
4. Компанийг татан буулгах эсэх болон татан буулгах комисс томилох;

Бодь даатгал нээлттэй компани болно

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны хамгийн сүүлийн

Хамгийн их арилжигдсан

Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн, сая төг	Эзлэх %
ADB	8,824,261	688.2	15.0%
MNDL	12,466,476	634.6	13.0%
ADU	804,919	539.9	11.0%
AARD	292,303	523.9	11.0%
APU	585,220	355.8	8.0%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их өссөн, тэрбум төгрөгөөр

Компани	2019.11.30	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
DAR	2.6	1.3	+100.9%
NEH	15.4	4.1	+37.0%
MIE	12.5	3.2	+34.4%
HSX	0.454	0.116	+34.3%
TAH	15.5	3.6	+31.0%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их буурсан, сая төгрөгөөр

Компани	2019.12.31	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
NKT	466.7	227.0	-32.7%
IND	618.9	224.5	-26.6%
SOH	1,236.2	412.0	-25.0%
DHU	1,591.3	457.1	-22.4%
ADL	3,718.5	819.3	-18.0%

ээлжит хуралдаанаар нийт 25 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн ба Бодь даатгал ХХК-ийн шинээр гаргаж буй үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрөл олгожээ.

Эрдэнэс Тавантолгойн 1072-той холбоотой мэдээлэл

Энэ хувьцаатай холбоотой 2019 оны сүүлээр цацагдсан шинэ мэдээлэл бол 2017-2019 оны ногдол ашгийг нөхөж олгоно гэсэн мэдээ байв. Үүнтэй холбоотой дараах зөвлөгөөг өгье.

- Ногдол ашиг тараана гэсэн албан ёсны цаасан дээр бууж баталгаажсан шийдвэр гараагүй байна.
- Хувьцааны дансаа нээлгэсэн бол дахиж 1072-т зориулж данс нээлгэх шаардлагагүй.
- Дансаа нээлгэсэн хүмүүс албан ёсны мэдээлэл гарсны дараа өөрийн брокерт хандах хэрэгтэй.
- Хувьцааны дансаа хараахан нээлгэж амжаагүй бол эртхэн нээлгэж байсан нь дээр байж магад. Сонгууль дөхөж байгаа тул юмыг яаж мэдэх вэ хэдэн төгрөг тараах ч юм билүү... Компани нь их л ашигтай ажилласан байна лээ.
- Дансаа манай онлайн системээр дараах линкээр орж нээж болно. <https://dbx.standardinvestment.mn/>
Лавлах утас - 70114433, 99027432

Хөрөнгийн зах зээлийн хураангуй тойм – 2019 он

Монголын хөрөнгийн биржийн I, II болон III-р ангилалд нийт 198 хувьцаат компани бүртгэлтэй байгаагаас төрийн өмчийн 18 хувьцаат компани, төрийн өмчийн оролцоотой 10 хувьцаат компани байгаа бөгөөд 2019 онд нийт 21 хувьцаат компани бүртгэлээс хасагдсан байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 53 үнэт цаасны буюу брокерийн компани Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,690.3 тэрбум төгрөг буюу 978.8 сая ам.долларт хүрчээ. Зах зээлийн үнэлгээг өнгөрсөн онтой харьцуулахад 7.1 хувиар өссөн нь 2011 болон 2017 оны өсөлттэй харьцуулахад хангалтгүй өсөлт хэдий ч бусад онуудын дунджаас дээгүүр байгаа бөгөөд зах зээлийн үнэлгээний 90.79 хувийг 30 компанийн үнэлгээ бүрдүүлсэн байна.

2019 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт 251 удаагийн арилжаагаар 132 компанийн 450.3 сая ширхэг хувьцаа нийт 133.5 тэрбум төгрөгөөр арилжагдсан нь өмнөх оноос 76.4 тэрбум төгрөгөөр (36.4%-аар), ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 97.4 мянган ширхэг Засгийн газрын бонд 9.7 тэрбум төгрөгөөр арилжагдсан нь өмнөх оноос 23.8 тэрбум төгрөгөөр (71%-аар), Монголын хөрөнгийн биржээр нийт 143.2 тэрбум төгрөгийн хэлцэл хийгдсэн нь өмнөх оноос 100.9 тэрбум төгрөгөөр (41.3%-аар) тус тус буурсан байна.

Хувьцааны арилжааны 41.87% буюу 55.9 тэрбум төгрөгийн арилжааг багцын арилжаа, 31.8% буюу 42.4 тэрбум төгрөгийн арилжааг анхдагч зах зээлийн арилжаа, 22.8% буюу 30.5 тэрбум төгрөгийг энгийн арилжаа, 3.5% буюу 4.6 тэрбум төгрөгийг тендер саналын арилжаа тус тус эзэлжээ.

ТОП-20 индекс 19,621.86 нэгж болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,844.90 нэгжээр буюу 8.59 хувиар буурчээ. Түүнчлэн, Монголын Хөрөнгийн Бирж нь 2019 оны 2-р сарын 19-ны өдрөөс эхлэн MSE A*, MSE B* индексийг албан ёсоор тооцож эхэлсэн. Тайлант хугацаанд MSE A индексийн дээд үзүүлэлт нь 10,268.81 нэгж, доод үзүүлэлт нь 8,163.84 нэгж, дундаж үзүүлэлт нь 9,247.29 нэгж, харин MSE B индексийн хувьд дээд үзүүлэлт нь 8,860.92 нэгж, доод үзүүлэлт нь 7,335.38 нэгж, дундаж үзүүлэлт нь 7,984.80 нэгж байсан байна.

2019 онд хөрөнгийн зах зээл дээр өрнөсөн онцлох үйл явдлаас дурдвал:

- Дөрвөн IPO хийгдсэн - Түмэн шувуут ХК, Ард Кредит ББСБ ХК, Монос Хүнс ХК, Инвескор ББСБ ХК анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгож, хөрөнгө амжилттай босгож чадсан.
- Бодь даатгал ХК нь анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгох зөвшөөрөл СЗХ-ноос авав.
- Хоёр урвуу нэгдэл хийгдсэн - Ард санхүүгийн нэгдэл ХХК нь Жинст-Увс ХК-д, мөн Монгол даатгал ХХК нь Хорго Хайрхан ХК-д тус тус нэгдэж, биржид бүртгэлтэй нээлттэй компани болсон.
- Мандал даатгал ХК нь хувьцаагаа 100 хуваах шийдвэр гаргаж, Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрснөөр хуваагдал хийгдсэн.

*MSE A индекс - тус индексийн багцад МХБ-ийн үнэт цаасны бүртгэлийн I ангилалд багтсан компаниудын үнэт цаас ордог.

*MSE B индекс - тус индексийн багцад МХБ-ийн үнэт цаасны бүртгэлийн II ангилалд багтсан компаниудын үнэт цаас ордог.

Та өөрөө гар утаснаасаа шууд арилжаа хийхийг хүсвэл манай “**Цахим данс**” системд бүртгүүлээрэй.



Мөн гар утасны **аппликэйшн** татан авч, онлайн арилжаа хийж, дансаа хянах боломжтой.

Хувьцааны дансаа нээлгээгүй бол мөн **онлайнаар нээгээрэй**.



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



МӨНГӨ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 11-р сарын эцэст 20.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 24.2 (0.1%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.8 (6.9%) их наяд төгрөгөөр өссөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 11-р сарын эцэст 860.2 тэрбум болж, өмнөх сараас 13.7 (1.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 34.9 (3.9%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.


Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018.11	2019.11*
Мөнгөний нийлүүлэлт, M2	18,651.4	20,446.0
Жилийн өөрчлөлт, %	25.8	9.6
Сарын өөрчлөлт, %	1.7	-0.1
Нийт хадгаламж	12,560.9	13,946.6
Жилийн өөрчлөлт, %	20.5	11.0
Сарын өөрчлөлт, %	3.2	1.1
Төгрөгийн хадгаламж	9,641.9	10,681.7
Жилийн өөрчлөлт, %	22.0	10.8
Сарын өөрчлөлт, %	2.1	0.6
Валютын хадгаламж	2,919.0	3,264.9
Жилийн өөрчлөлт, %	15.6	11.8
Сарын өөрчлөлт, %	6.8	3.1

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 11-р сарын эцэст 18.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 34.1 (0.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1.4 (8.7%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 11-р сарын эцэст 968.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 16.0 (1.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 5.5 (0.6%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 11-р сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 10.8 (0.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 149.1 (7.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Зураг 31. Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг



УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 9.7 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 9.2 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 486.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 11-р сард 842.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 252.0 (23.0%) тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 901.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 132.5 (12.8%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг 35. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.1 тэрбум ам. долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 394.6 сая ам. доллараар буурчээ. Урсгал данс 1.2 тэрбум ам. долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.3 тэрбум ам. доллар, анхдагч орлогын данс 1.2 тэрбум ам. долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 36. Бараа болон үйлчилгээний худалдааны тэнцэл, сараар, сая америк доллараар



ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2019 оны эхний 11 сард дэлхийн 150 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.6 тэрбум ам. доллар, үүнээс экспорт 7.1 тэрбум ам. доллар, импорт 5.6 тэрбум ам. долларт хүрлээ. Харин 2019 оны 11-р сард экспорт 526.9 сая ам. доллар, импорт 519.3 сая ам. доллар болж, өмнөх сараас экспорт 55.7 сая ам. доллараар буурч, импорт 53.5 сая ам. доллараар өсжээ.

Зураг 37. Экспорт, импорт, тэнцэл, сараар, сая америк доллар



Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 787.1 (6.6%) сая ам. доллар, үүнээс экспорт 574.8 (8.9%) сая ам. доллараар, импорт 212.3 (4.0%) сая ам. доллараар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2018 оны 11 сард 1.1 тэрбум ам. долларын ашигтай гарч байсан бол 2019 оны 11 сард өмнөх оны мөн үеэс 362.6 сая ам. доллараар нэмэгдэж, 1.5 тэрбум ам. долларт хүрчээ.



ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.4 хувиар буурсан бол, өмнөх оны эцсээс 4.6%, өмнөх оны мөн үеэс 5.2%-р өссөн байна.

Зураг 38. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар = 100%), хувь



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11-р сард өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.5 хувь (мах, махан бүтээгдхүүн 21.9 хувь, согтууруулах бүс ундааны бүлэг 4.2 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.0 хувь (цахилгаан, хийн бусад түлшний дэд бүлгийн үнэ 2.9 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
6-р хороо, Бага тойруу 24,
Монреимпекс ХХК-ийн байр,
2-р давхар, 201 тоот

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дүрдсэн үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

©2019 Стандарт инвестмент ҮЦК